

## ЭРДЭНЭ РЕСУРС БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ОРДООС ХОЙШ 3.5 КМ ЗАЙД ШИНЭ АЛТНЫ НЭЭЛТ ХИЙЛЭЭ ХАР МОРЬ ТАЛБАЙД 6 Г/Т АЛТНЫ АГУУЛГА БҮХИЙ 45 МЕТРИЙН ИНТЕРВАЛ ОГТЛОВ

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот

2021.01.06

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) Хар Морь талбайд хийгдсэн хайгуулын хөтөлбөрийн үр дүнг танилцуулахад таатай байна.

### Онцлох мэдээлэл<sup>1</sup>:

- Хар Морь талбайн баруун хэсэгт 4 км үргэлжлэх бүс нь газрын дөт гүнд өндөр агуулга бүхий алтны эрдэсжилт агуулж байгаа нь Баян Хөндий ордын ойролцоо томоохон алтны нээлтүүдийг хийх боломжтойг батлав:
  - AAD-58 цооногт 10 метрийн гүнээс эхлэн 5.97 г/т алтны агуулга бүхий 45 метрийн интервал огтолсон нь 27.1 г/т алтны агуулга бүхий 8 метрийн интервал агуулж, үүнд 82.5 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал багтаж байна.
  - AAD-58 цооногоос хойд зүгт 180 метрт орших AAD-57 цооногт 52 метрийн гүнээс эхлэн 0.6 г/т алтны агуулга бүхий 16 метрийн интервал, 194 метрийн гүнээс эхлэн 1.2 г/т алтны агуулга бүхий 48 метрийн интервал огтолсон нь 1.7 г/т алтны агуулга бүхий 30 метрийн интервал агуулж байна.
  - AAD-57 цооногоос хойд зүгт 1 км зайтай AAD-51 цооногт 138 метрийн гүнээс эхлэн 5.6 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал, 222 метрийн гүнээс эхлэн 0.9 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервал огтолсон.
  - Эрдэсжсэн трендийн дагуу AAD-57 цооногоос хойд зүгт 500 метрт өрөмдсөн AAD-61 цооног болон Хар Морь зүүн хойд гол структурын дагуу зүүн хойд зүгт 750 метрт өрөмдсөн AAD-60 цооногийн үр дүнгүүд хүлээгдэж байна.
- Алтны эрдэсжилт нь соронзон бага орны дагуу Хойд-Өмнөд (N-S) структурын дагуу хөрсөн дэх алтны аномаль, эпипермаль брекч болон штокверк судалтай давхцаж байгаа юм.
  - AAD-57 ба 58 цооногууд нь Хар Морь талбайн Хойд-Өмнөд (N-S) структур, зүүн-хойд трендийн огтлол дээр оршиж, томоохон соронзонгийн нам, өндөр IP туйлшралын аномальтай давхцаж байна.
    - Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц<sup>2</sup> (“Measured and Indicated Resources”)<sup>3</sup>, 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (“Inferred Resources”) тодорхойлогдсон.
- Энэхүү сонирхолтой нээлтийг үргэлжлүүлэн судлах томоохон хайгуулын хөтөлбөрийг 2021 оны 1-р улиралд гүйцэтгэхээр төлөвлөж байна.

<sup>1</sup> Хэвлэлийн мэдээнд тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зугаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропийг тодорхойлох боломжтой.

<sup>2</sup> Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2019 оны 12 сарын 4-нд Тетра Текийн боловсруулсан NI 43-101 техникийн тайлангаас танилцана уу.

<sup>3</sup> Баттай ба бодит геологийн нөөц: 3.77 г/т алтны агуулга бүхий 171,000 унц баттай нөөц, 2.93 г/т алтны агуулга бүхий 349,700 унц бодит нөөц

## Тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Хар Морь талбай нь Баян Хөндий алтны ордын нээлтээс хойш бидний илрүүлсэн хамгийн чухал эрдэсжсэн бүс болж байна. Энэхүү шинэ, өндөр агуулга бүхий өрөмдлөгийн огтлолууд болон дөрвөн км үргэлжлэх эрдэсжсэн трендийн геофизик, геохимийн шинж чанарууд нь Хар Морь талбайг хэтийн төлөв өндөртэйг илтгэж байна.”

“Энэхүү амжилтыг авчирсан хайгуулын багтаа баяр хүргэж, талархал илэрхийлье. Манай хайгуулын баг гурван ордыг нээж, Хөндий Алтны Дүүрэгт Хар Морь зэрэг хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлж ажилласан. Эдгээр үр дүнгүүд нь тусдаа нээлтүүд боловч хэд хэдэн талбайн структур болон хувирлын ижил төстэй онцлогууд нь Хөндий системийн хэтийн төлөвийг ойлгоход чухал ач холбогдолтой. Бид эдгээр үр дүнд сэтгэл хангалуун байгаа ба 2021 оны эхний улиралд эхлүүлэхээр төлөвлөж буй өрөмдлөгийн хөтөлбөрөөр Эрдэнэ Ресурсийн Хөндий Алтны Дүүрэг нь дэлхийн хэмжээний алтны системийг агуулж байгааг тодорхойлох үр дүнгүүд гарна хэмээн найдаж байна.” хэмээн танилцууллаа.

## Хар Морь (Dark Horse) нээлтийн тухай

(План зураг болон хөндлөн зүсэлтийн зурагтай хавсралтаас танилцана уу)

2020 оны 12 сард эцэслэсэн Хар Морь талбайн 2-р үе шатны өрөмдлөгийн хөтөлбөрөөр нэмэлт 3,085 метр, 14 цооног өрөмдсөн. 2020 онд Эрдэнэ Ресурс нь Хар Морь талбайд нийт 4,660 метр, 25 цооног (AAD-40 -аас 64 хүртэл) өрөмдсөн. 2-р үе шатны өрөмдлөг нь тэлэлтийн бүсүүдийн тайлал бүхий томоохон структуртай холбоотой индикатор элементүүд (As, Mo, Sb)-ийн огтлол, бага соронзонгийн гажилт болон хөрсөн дэх алтны гажилттай холбоотой структуруудын огтлол бүхий 1-р үе шатны өрөмдлөгийн үр дүнд тулгуурласан.

Энэхүү шинэ нээлт нь Хар Морь талбайн хязгаарлагдмал судлагдсан, Хойд-Өмнөд (N-S) тренд структурын дагуу нам соронзон, эпитеpmаль брекч ба штокверк судлын байршил болон 4 км үргэлжлэх хөрсөн дэх алтны гажилтын трендийн дагуу бүсэд байрлаж байна. AAD-48 цооногоос ([2020 оны 10 сарын 26-ны хэвлэлийн мэдээтэй танилцана уу](#)) баруун зүгт 1 км-т орших AAD-51, AAD-57 болон AAD-58 цооногуудыг Хойд-Өмнөд (N-S) структурыг судлахаар өрөмдсөн. Хойд-Өмнөд структур нь Баян Хөндий ордоос 1 км-т Эрдэнэ Ресурсийн 100% эзэмшил бүхий 2,309 га Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд өмнө зүг рүү Алтан Сум-ын хагарал, хойд зүгт Төв Нээлтийн Бүс хүртэл 3 км үргэлжлэн оршдог.

Нээлтийн гол бүс (AAD-57 ба AAD-58) нь томоохон соронзонгийн нам, өндөр IP туйлшрал шинж чанар бүхий хөрсөн дэх алтны гажилттай холбоотой Хойд-Өмнөд (N-S) структур ба Хар Морь талбайн зүүн хойд трендийн огтлол дээр байрлаж байна. Хойд зүгт нэг км зайд Хойд-Өмнөд (N-S) структурын дагуу AAD-51 цооногт 136 метрийн гүнд 5.6 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал, 222 метрийн гүнд 0.9 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервал зэрэг хэд хэдэн алтны аномаль бүс огтолсон. Структурын хойд бүсэд, AAD-57 цооногоос хойд зүгт 500 метрт өрөмдсөн AAD-61 цооногийн үр дүн хүлээгдэж байна. Гол нээлтийн бүсээс өмнө зүгт Хойд-Өмнөд (N-S) структур нь туфаас тогтсон цахиуржсан ба цагаан гялтгануур бүхий галт уулын чулуулгийн зузаан багцыг огтолсон кварц-гематит судлууд ба штокверк брекчийн дундаж ба хүчтэй тархсан пирит бүхий индикатор элементүүд, бага түвшний боловч аномаль алт илэрсэн AAD-33 цооног (2019 онд Төв Структурын Бүсэд өрөмдсөн 85 метр цооног) хүртэл 1.3 км хүртэл үргэлжилж (судлагдаагүй) байна.

**Хар Морь 2-р үе шатны хайгуулын хөтөлбөрийн үр дүн (0.3 г/т алтны агуулгаас дээш агуулга бүхий интервалууд)**

Цооног	(м) -ээс	(м) хүртэл	Интервал <sup>(1)</sup>	г/т Алт <sup>(2)</sup>
AAD-51	138	141	3	5.61
Үүнд	140	141	1	16.22
Ба	222	232	10	0.92
AAD-52	42	60	18	0.32
Ба	83	86	3	1.00
AAD-55	4	6	2	2.28
AAD-57	52	68	16	0.58
Ба	160	180	20	0.45
Ба	194	242	48	1.18
Үүнд	202	232	30	1.74
AAD-58	10	55	45	5.97
Үүнд	32	54	22	11.98
Үүнд	36	37	1	21.18
үүнд <sup>(3)</sup>	41	49	8	27.07
үүнд	43	44	1	82.53

<sup>1</sup> Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Хар Морь талбайд эрдэсжсэн бүсийн чиглэлийг тодорхойлох хангалттай өрөмдлөг хийгдээгүй тул одоогоор бодит зузааныг тодорхойлох боломжгүй. Хайгуулын өрөмдлөгийн цооногууд нь (зөв өнцгөөр) 45-75 градусын уналтаар энгийнээс боломжит эрдэсжсэн талбайн трендийн дагуу өрөмдсөн

<sup>2</sup> Тайлагнасан интервалын агуулга нь дунджаар 1-2 метр интервалын дээжид тулгуурласан жигнэсэн дундаж агуулга болно. Дээд хязгаарлалт хийгээгүй боловч 10 г/т алтны агуулгаас өндөр агуулга бүхий интервалыг тодруулахаар тусад нь тайлагнадаг.

<sup>3</sup> 1 метр интервал бүхий 8 дээжийн 7-д нь 10 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн ба 8 дахь дээжид 9.5 г/т алтны агуулга илэрсэн. Хамгийн өндөр агуулга бүхий интервал (43-44 метр) -ыг тусад нь тайлагнасан.

Тэмдэглэл: AAD-50, AAD-53, AAD-54, AAD-56 ба AAD-59 цооногуудад аномаль алт ба/эсвэл индикатор элементүүд (As, Mo, Sb) огтолсон боловч 0.3 г/т алтны агуулгаас өндөр интервал огтлоогүй.

Соронзон газрын зураг дээр Хойд-Өмнөд (N-S) структур нь энэхүү структур ба Хар Морь талбайн онцлох зүүн хойд трендийн структурын дагуу хэд хэдэн бүсийг огтолсон нь тодорхой харагдаж байна. Өнөөгийн структурын тайллаар Хойд-Өмнөд (N-S) тренд структур нь баруун ба баруун өмнөд зүгээс тектоник шахалтаас үүссэн тэлэлтийн бүсийг илэрхийлж байна гэж үзэж байна (Kloppenburger, 2017).

Газрын гадарга дээр, AAD-57 ба AAD-58 цооногууд нь порфирийн андезит нэгдэл болон өндөр түвшний эпиптермаль эсвэл литокап төрлийн орчныг илэрхийлэх үлдэгдэл цахиур кварцын цуврал биетэд (200-300 метрийн өргөн) багтаж байна. AAD-57 ба AAD-58 цооногууд нь хоорондоо 180 метрийн зайтай, зүүн хойд структурын дагуу Хойд-Өмнөд чигтэй сунасан соронзон нам өргөн бүс (100м-ээс 500 м)-д байрладаг. Энэхүү соронзон шинж чанарыг соронзон гүрийн сарнилын нөлөөгөөр хүчтэй гидротермал хувиралд орсон бүс хэмээн одоогоор тайлж байна. (IP) геофизик нь эрдэсжсэн бүсийн өндөр сульфидийн агууламж бүхий талбайд илэрдэг харьцангуй хүчтэй туйлшралын утга нь соронзон бага шинж чанар болон хөрсний геохимийн шинж чанартай давхцадаг.

AAD-58 цооногийг Хойд-Өмнөд / Зүүн Хойд структурын огтлолтой холбоотой соронзон нам, хүчтэй туйлшралын утга болон геохимийн (алт-хүнцэл) гажилттай давхцсаныг шалгах аар зүүн өмнө (135 градус) зүг рүү азимутын 45 градусын налууд өрөмдсөн. Энэхүү цооногийг кварц- серицит-пиритийн хувирал бүхий хүчтэй хувирсан нарийн ширхэгт галт уулын үеллийн хүрээнд өрөмдсөн. Цооногийн алтны эрдэсжилт нь (5.97 г/т алтны агуулга бүхий 45 метр) хүчтэй цахиуржсан өргөн бүс (10-55 метр), цагаан

гялтгануур (серицит)-ийн хувирал ба исэлдсэн (сульфидын дараах төмрийн исэл) хувиралтай холбогдож байна. Интервалын судал нь кварц-сульфид (пирит-лимонит)-ийн царцдас бүтэцтэй байгаа нь штокверк болон хучигдсан шинж чанарыг харуулж байна. Хамгийн хүчтэй алтны эрдэсжилт болох 27 г/т алтны агуулга бүхий 8 метрийн интервал (41-49 метр) нь геохимийн хувьд алтны аномаль, хүнцэл, антимон, молибден, зэс зэрэг хүчтэй исэлдсэн хар эпитеpmаль брекчийн бүсэд оршдог.

AAD-57 цооног нь зүүн (90 градус) азимутын дагуу 75 градусын турш өрөмдсөн 251 метр гүн цооног юм. Энэхүү цооног нь AAD-58 цооноогоос хойд зүгт 180 метрт оршиж байгаа бөгөөд 2018 онд өрөмдөн, алт, хүнцэл, антимон, зэсийн аномаль илэрсэн AAD-34 хайгуулын цооногийг үргэлжлүүлэн судлах зорилгоор өрөмдсөн. AAD-57 цооног нь Хойд-Өмнөд / Зүүн Хойд структурын огтлолтой холбоотой соронзон нам, хүчтэй туйлшралын утга илэрсэн AAD-58 цооногтой ойр оршиж байна. Энэхүү цооног нь хүчтэй хувирсан цагаан гялтгануур (серицит) ба дунджаас хүчтэй цахиуржсан туф болон брекчсэн галт уулын үелэлд байрладаг. AAD-57 цооногийн алтны эрдэсжилт нь хүчтэй цахиуржсан өргөн бүс болон кварц-карбонат-сульфид (арсенопирит ± пирит) штокверк судлаар давамгайлсан цагаан гялтгануурын (серицит) хувиралтай холбоотой. AAD-58 цооногтой адил AAD-57 цооног нь сульфид (арсенопирит ба пирит)-ын концентрац ба аномаль антимон нь алтны эрдэсжилттэй давхцаж байгаа боловч AAD-57 цооногийн сульфидын исэлдлийн эрч нь AAD-58 цооногийн үр дүнгээс бага байгаа нь гүн рүү сунасантай холбоотой.

AAD-58 цооноогоос хойд зүгт 1.2 км зайд 250 гүн AAD-51 цооногийг Хойд-Өмнөд (N-S) структурын шинж чанарыг шалгах зорилгоор зүүн өмнөд (135 градус) азимутын 45 градусын дагуу өрөмдсөн. Энэхүү цооногийг алтны аномаль эрдэсжилт огтолсон AAD-18 (2018) цооногийг үргэлжлүүлэн судлахаар өрөмдсөн. AAD-51 цооногт 16.2 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал багтаасан 5.6 г/т алтны агуулга бүхий 3 метрийн (138-141 метр) интервал болон 0.92 г/т алтны агуулга бүхий 10 метрийн (222-232 метр) интервал огтолсон. Алтны эрдэсжилт нь кварц-лимонит штокверк судлууд болон эпитеpmаль хэв маягийн брекчийг агуулсан хүчтэй хувирсан цагаан гялтгануурын үелэл туф нэгдэлтэй холбоотой.

Хар Морь талбайн бусад бүсэд AAD-52 ба AAD-55 алмазан өрөмдлөгийн цооногуудад аномаль алт илэрсэн бөгөөд үүнд: AAD-52 цооногт: 42 метрийн гүнд 0.3 г/т алтны агуулга бүхий 18 метрийн интервал болон 83 метрийн гүнд 1.0 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал огтолсон. AAD-55 цооногт: 4 метрийн гүнээс эхлэн 2.3 г/т алтны агуулга бүхий 2 метрийн интервал огтолсон. Эдгээр бүсийг ирээдүйн хайгуулын хөтөлбөрөөр үргэлжлүүлэн судална.

### COVID-19 цар тахлын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ:

2020 оны 11 сард Covid-19 вирусний халдвар голомтлон тархсанаас үүдэн Монгол Улсын Засгийн газар дотоодын хөл хөдөлгөөн, бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний салбарт хязгаарлалт хийгээд байна. Компанийн Монгол Улс дахь ажилтнууд компанийн болон Монгол Улсаас гаргасан протоколын дагуу ажиллан, 2020 оны 12-р сард хайгуулын хөтөлбөрийг эцэслэсэн. Улаанбаатар хотын хөл хорио нь 2021 оны 1 сарын 11 хүртэл сунгагдсан боловч Монгол Улсын бусад аймгуудад хөл хориог сулруулах хандлагатай байна. 2021 оны 1-р улиралд компани нь Засгийн газрын уул уурхай, ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагааны удирдамжийн дагуу хайгуулын хөтөлбөрийг эхлүүлэхээр төлөвлөж байна.

COVID-19 вирусний тархалтаас урьдчилан сэргийлэхэд бие сэтгэлээ зориулж буй эрүүл мэндийн ажилтан албан хаагчид, цагдаа, тусгай үүргийн албан хаагч нартаа компанийн зүгээс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

## Хөндий Алтны Дүүргийн Тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц<sup>4</sup> (“Measured and Indicated Resources”)<sup>5</sup>, 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (“Inferred Resources”) тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтаж байна. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7 сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Нарийвчилсан ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор боловсруулахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2022 онд эхлүүлнэ.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com) -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

## Мэргэшсэн этгээд (геологч) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”) -ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмет спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screenmetallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 г дээжний 75 микроноос бага байх 30 г бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

<sup>4</sup> Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2019 оны 12 сарын 4-нд SEDAR-т байршуулсан Тетра Текийн боловсруулсан NI 43-101 техникийн тайлангаас танилцана уу.

<sup>5</sup> Баттай ба бодит геологийн нөөц: 3.77 г/т алтны агуулга бүхий 171,000 унц баттай нөөц, 2.93 г/т алтны агуулга бүхий 349,700 унц бодит нөөц

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцганд үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн хийж Улаанбаатар дахь Эс Жи Эс ("SGS") лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнийн ложистикийн гэрээт компани Монруд ХХК гүйцэтгэдэг.

## Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

## ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

### Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал  
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419  
И-мэйл: [info@erdene.com](mailto:info@erdene.com)  
Twitter: <https://twitter.com/ErdeneRes>  
Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>  
LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>  
YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>

# KHUNDII GOLD DISTRICT

Three deposits, multiple greenfield discoveries, limited exploration

**Altan Nar Deposit** (Au, Ag, Zn, Pb)

Nomin Tal

Road to Shinejinst

Oyut Khundii

Proposed Haulroad

Altan Arrow

Khuvyn Khar

**Dark Horse Gold Prospect**

**Zuun Mod Deposit** (Cu, Mo)



Ulaan

Khundii North

**Bayan Khundii Deposit** (Au)



# DARK HORSE-BAYAN KHUNDII PLAN MAP - STRUCTURAL RELATIONSHIP





# DARK HORSE PROSPECT

## Q4 2020 Phase II Drilling Magnetics and Structural Lineations

**AAD-51**  
3m of 5.6 g/t Au  
Incl. 1m of 16.2 g/t Au  
And  
5m of 1.4g/t Au

**AAD-61**  
(Results Pending)  
Intensely silicified and white mica  
altered epithermal breccia  
intersected

**AAD-57**  
48m of 1.2 g/t Au

**AAD-58**  
45m of 6.0 g/t Au  
Incl.  
8m of 27 g/t Au

**Altan Arrow Structure**

**AAD-02**  
28m of 0.39 g/t Au

**AAD-11**  
1m of 39.1 g/t Au

**AAD-03**  
**AAD-12\***  
2m of 23.5 g/t Au  
2m of 70 g/t Au\*

**AAD-52**  
18m of 0.32 g/t Au

**AAD-53**

**AAD-54**

**AAD-55**

**AAD-63**

**AAD-41**  
1m of 10.6 g/t Au

**Dark Horse Structures**

**AAD-48**  
1m of 30.6 g/t Au

**AAD-60**  
(Results Pending)  
Intense phyllic alteration zone:  
Epithermal breccia and stockwork  
quartz veins intersected


North-South Corridor

SECTION A


**AAD**

- Phase - 2 2020 Collar
- Previously Reported Drillhole
- Structural Lineations and Dilation Zones
- Section Axis

1 km



# MAGNETICS



# IP CHARGEABILITY

